

**БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**

С.АМАРСАЙХАН

2026 оны 08 дугаар сарын 12-ны өдөр

**АВЛИГЫН ХӨРӨНГИЙГ ХУРААЖ, ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН САНД ТӨВЛӨРҮҮЛЖ ЗАРЦУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1. Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэж, Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно” гэж, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно” гэж, мөн зүйлийн 14 дэх заалтад “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно,” гэж тус тус заасан.

Иймд авлигын хөрөнгийг хураан авах зохицуулалт нь шударга ёс, хууль дээдлэх зарчмыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ өмчлөх эрх, шүүхээр хамгаалуулах эрх, өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх болон гэм буруугүйд тооцох зарчмыг хөндөхгүй, хууль ёсны, зайлшгүй, зорилгодоо нийцсэн, тэнцвэртэй хязгаарлалт байх шаардлагатай.

Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 58/4 дүгээр тогтоолоор баталсан Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцыг 2005 оны 10 дугаар сарын 27-ны өдөр соёрхон баталсан. Конвенцын 20 дугаар зүйлд “Хууль бусаар баяжих санаатай үйлдлийг, өөрөөр хэлбэл, төрийн албан тушаалтан хөрөнгө нь их хэмжээгээр нэмэгдсэнийг өөрийнхөө хууль ёсны орлоготой холбогдуулан үндэслэлтэйгээр тайлбарлаж чадахгүй байгаа бол ийнхүү хөрөнгө нь нэмэгдсэнийг гэмт хэрэг гэж тогтооход шаардлагатай байж болох хууль тогтоох болон бусад арга хэмжээг авах асуудлыг оролцогч улс бүр үндсэн хууль болон эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн авч үзнэ.” гэж заасан бөгөөд мөн конвенцын 31 дүгээр зүйл нь

гэмт хэргийн орлого, түүнтэй адилтгах үнэ бүхий хөрөнгө, орлогыг илрүүлэх, царцаах, битүүмжлэх, хураах арга хэмжээг, 54 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн (с) заалт нь гэмт этгээд нас барсан, оргон зайлсан, эзгүй байгаа болон эрүүгийн журмаар яллах боломжгүй бусад тохиромжтой тохиолдолд ял шийтгэлээс үл хамааран хөрөнгө хураах боломжийг авч үзэхийг, 57 дугаар зүйл нь хураасан хөрөнгийг буцаах, захиран зарцуулахтай холбоотой харилцааг тус тус зохицуулсан. Конвенцын удиртгалд эдгээр зохицуулалтыг хэрэгжүүлэхдээ эрүүгийн, иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн зарчим, процессын баталгааг чанд хангах шаардлагыг онцлон тэмдэглэсэн байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгаснаар “... хүний эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно.” хэмээх зорилгыг тодорхойлж, улмаар тус зорилгыг хэрэгжүүлэхээр “Авлигагүй засаглал” буюу “Үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулна.” хэмээх зорилтуудыг дэвшүүлжээ.

Түүнчлэн, тус зорилтуудыг хэрэгжүүлэх I үе шат (2021-2030)-нд “Нийгмийн бүх түвшинд шударга ёсыг бэхжүүлэх бодлогын болон хууль, эрх зүйн орчин бүрдэнэ.” гэж, “Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагаа, зохион байгуулалтыг сайжруулж, авлига албан тушаалын гэмт хэрэг буурсан байна.” хэмээх үр дүнд хүрэхээр тодорхойлжээ.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 6.1.4-т “Хөрөнгө буцаасан, хураасан, царцаасан хөрөнгийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн орчныг бүрдүүлнэ.” гэж, 6.3.1-д “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүн нас барсан, сураггүй алга болсон, оргон зайлснаас үл хамааран шүүхийн шийдвэрээр хурааж, улсын орлого болгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.” гэж, 6.3.2-т “Оффшор бүс, гадаад улсаас шилжүүлэн авсан хууль бус хөрөнгө, орлого, авлигын гэмт хэргийг шийдвэрлэх явцад хураасан хөрөнгийг нээлттэй, ил тод байдлаар зарцуулах тогтолцоог бий болгоно.” гэж, 6.3.3-т “Нуугдмал хөрөнгийг илрүүлэх, хөрөнгө буцаах болон захиран зарцуулах нөхцөл, журам, мөнгө угаах, үндэслэлгүйгээр хөрөнгөжих үйлдлийг таслан зогсооход чиглэсэн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.” гэж тус тус заасан.

Мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой хөгжлийн зорилтод тусгагдсан гол зорилт болох Зорилт 16-д “санхүүгийн ... хууль бус урсгалыг мэдэгдэхүйц бууруулах, хулгайлагдсан хөрөнгийг буцаан авах ажиллагааг бэхжүүлэх, бүх төрлийн зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх” гэж мөн онцлон тодотгон тусгасныг нэмж дурдах нь зүйтэй.

Иймд авлигын хөрөнгийг хуульд заасан тодорхой процесстойгоор, прокурорын хяналттайгаар, шүүхийн шийдвэрээр хураан авах, хураан авсан хөрөнгийг эрхлэн удирдах, зохистой захиран зарцуулах нэгдмэл зохицуулалт бий болгож эрх зүйн орчин бүрдүүлэх нь дээрх хууль тогтоомж, олон улсын гэрээ, бодлогын баримт бичгүүдийг хэрэгжүүлэхэд чухал алхам болно.

1.2. Практик үндэслэл, шаардлага

1.Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7, 7.1.8-д албан тушаалтан албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх, үндэслэлгүйгээр хөрөнгөжихийг хориглосон бөгөөд мөн зүйлийн тайлбарт “Албан

тушаалтан зургаан сарын албан тушаалын цалин хөлс, орлогоос илүү хөрөнгө, орлогыг хууль ёсны дагуу олсон болохыгоо үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй тохиолдолд үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэж үзнэ.” гэж тодорхойлсон байдаг.

Мөн тус хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэгт шүүгч энэ хуулийн 7.1.7, 7.1.8-д заасныг зөрчсөн этгээдийн тухайн олсон эд хөрөнгө, орлогыг хураах буюу давуу эрхийг хүчингүй болгохоор заасан.

Гэвч Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7, 7.1.8 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсгийг хэрэгжүүлэх процессын хууль байхгүй байна. Тухайлбал, Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8-д заасан “хөрөнгө, орлогыг хууль ёсны дагуу олсон болохыгоо үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй” гэдгийг хууль хэрэглээний хувьд хэрхэн ойлгох нь тодорхой бус буюу тус ойлголтод хууль бус гарал, эх үүсвэртэй хөрөнгө хамаарах эсэх нь тодорхой бус байна. Үүнээс гадна тус хуулийн 7.1.7, 7.1.8-д заасныг зөрчснийг шалгах, тогтоох, хууль ёсны орлогоос давсан хөрөнгийг илрүүлэх, шалгах ажиллагаа, үндэслэл, журам, уг ажиллагааг хэрэгжүүлэх эрх бүхий субъект, хураах санал шүүхэд хүргүүлэх субъект, журам, шүүхийн харьяалал болон шүүхээс хянан шийдвэрлэх журам, нотолгооны стандарт, талуудын нотлох үүргийн хуваарилалт, хөрөнгийн бүрэн бүтэн байдал, үнэ цэнийг түр хамгаалах арга хэмжээ, шударга эзэмшигч, гуравдагч этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын хамгаалалт, баталгааг хангах зэрэг бусад шаардлагатай асуудлыг зохицуулсан эрх зүйн орчин бүрдээгүй байна.

Хөрөнгө, орлогын эх үүсвэрээ тайлбарлаж чадаагүй гэх ганц нөхцөлөөр өмчлөх эрхийг хязгаарлан хураах нь хангалтгүй бөгөөд төрөөс эхлээд орлого, хөрөнгийн үл нийцэл, албан тушаалтай холбоотой объектив нөхцөл, хөрөнгийн бодит өмчлөл, захиран зарцуулалтыг тогтоож, хүний эрхийн зөрчлөөс сэргийлж тодорхой хяналттайгаар хөрөнгө шалгах ажиллагааг явуулж байх шаардлагатай.

2.Авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хөрөнгө, орлогыг битүүмжлэх, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураахтай холбоотой зохицуулалт Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон бусад салбар хуульд туссан.

Авлигын зөрчлийг Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлээр, ашиг сонирхлын зөрчлийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар, бусад зөрчлийг Зөрчлийн тухай хуулиар тус тус тодорхойлсон.

Зөрчлийн тухай хуульд заасан зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагааны журам Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар зохицуулагдаж, зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлого, зөрчлийн улмаас бусдад учирсан хохирлыг нөхөн төлүүлэх механизм зохицуулагдаж байна.

Гэвч Авлигын эсрэг хуульд заасан авлигын зөрчлийг шалган шийдвэрлэх, авлигын зөрчлийн улмаас бий болсон хөрөнгө, орлогыг хураах, бусдад учирсан хохирлыг нөхөн төлүүлэх ажиллагааг хэрэгжүүлэх механизм хуульчлагдаагүй байна.

Иймд дээрх зохицуулалт хоорондын уялдаа, ажиллагааны дараалал, эрх бүхий байгууллагын чиг үүрэг, гомдол, мэдээлэл хуваарилалт, мэдээлэл солилцох

үндэслэл, хураасан хөрөнгийг хамгаалах, удирдах, захиран зарцуулах тогтолцоо нэг мөр болоогүй гэж үзэхээр байна.

3.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураах боломж нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нас барсан, оргон зайлсан, сураггүй алга болсон, халдашгүй байдал, харьяаллын хүндрэл, гадаад улсад оршин суух зэрэг шалтгаанаар эрүүгийн хэргийг эцэслэн шийдвэрлэх боломжгүй болсон үед хязгаарлагддаг. Ийм нөхцөлд эрүүгийн гэм бурууг тогтоохгүйгээр, зөвхөн хөрөнгийн хууль ёсны эх үүсвэр, өмчлөл, эзэмшил, хяналт, шилжилтийг шүүхээр хянан шийдвэрлэх механизм байхгүйгээс хууль бус хөрөнгө эдийн засгийн эргэлтэд үлдэх, бусдад шилжих, нуун далдлагдах эрсдэл үүсэж байна.

Тус эрсдэл Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураахад мөн адил үүсэж байна. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар холбогдогч нас барсан, оргон зайлсан, сураггүй алга болсон, хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх мэт шалтгаанаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах боломжгүй нөхцөл байдалд хүрдэг. Үүний улмаас зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлого хураагдалгүйгээр үлдэх буюу эдийн засгийн эргэлтэд хэвээр үлдэх, бусдад шилжих, нуун далдлагдах эрсдэл үүсэхээр байна.

4.Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссанаас үл хамааран шүүхийн шийдвэрээр хурааж улсын орлого болгоно.” гэж заасан хэдий ч тус заалтыг хэрэгжүүлэх процессийн зохицуулалт хуульчлагдаагүй байна.

5.Хөрөнгийг битүүмжлэх, түр хураах, хадгалах, арчлах, үнэлэх, ашиглалтын хэвийн байдлыг хамгаалах, үр шимийг бүртгэх, үнэ цэн буурах хөрөнгийг шүүхийн зөвшөөрлөөр урьдчилан борлуулах, шүүхийн эцсийн шийдвэрийн дараа цахим дуудлага худалдаагаар захиран зарцуулах, олсон орлогыг хохирогчид нөхөн төлөх, зардалд тооцох, улсын төсөвт төвлөрүүлэх дараалал зэргийн асуудал хуулиар тодорхой бус байна. Иймээс түр хураасан, битүүмжилсэн, хураасан хөрөнгө муудах, үрэгдэх, үнэ цэнээ алдах, үүнээс үүдэн хохирол нөхөн төлөгдөхгүй байх, удирдлагын зардал өсөх, захиран зарцуулах ажиллагаанд ашиг сонирхлын зөрчил, авлигын эрсдэл үүсэх нөхцөл бүрдэж байна.

6.Авлигын гэмт хэргийн 2017-2023 оны шийдвэрлэлтийн талаарх тоон мэдээллээс үзэхэд Авлигатай тэмцэх газар энэ хугацаанд нийт 8,860 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж, үүнээс 1,578 хэргийг шүүхэд шилжүүлэх, 2,988 хэргийг хэрэгсэхгүй болгох саналтайгаар тус тус шийдвэрлэсэн байна. Прокурорын байгууллага мөн хугацаанд нийт 7,229 авлигын гэмт хэрэгт хяналт тавьж, 1,005 хэрэгт яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлж, 121 хэргийг прокурорын шатанд хэрэгсэхгүй болгожээ. Прокурорын байгууллагаас шүүхэд шилжүүлсэн 1,005 хэргээс шүүх 739 хэргийг хянан шийдвэрлэж, 20 хэргийг хэрэгсэхгүй болгосон бөгөөд бусад хэрэг нь хянан шийдвэрлэх ажиллагааны шатанд байсан байна. Эдгээр мэдээллийг нэгтгэн үзвэл 2017-2023 онд мөрдөн шалгах ажиллагаа явуулсан нийт 8,860 авлигын гэмт хэргийн 739 буюу 8.3 хувь нь шүүхээр хянан шийдвэрлэгдсэн бол мөрдөн шалгах, прокурорын хяналт болон шүүхийн шатанд нийт 3,129 хэрэг буюу 35 орчим хувийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

Авлигын гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураан авч улсын орлого болгосон байдалд холбогдох байгууллагуудаас ирүүлсэн тоон мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийхэд 2018-2023 онд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын

ажиллагаа явуулсан авлигын гэмт хэргийн улмаас нийт 1.5 их наяд төгрөгийн хохирол учирч, 865.4 тэрбум төгрөгийн хөрөнгийг битүүмжилсэн боловч прокурорын байгууллагын мэдээллээр тухайн хугацаанд нийт 14.9 тэрбум төгрөгийн хөрөнгө, орлогыг хураан авсан байна. Харин Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн 2018-2023 онд шүүхээр хянан шийдвэрлэсэн авлигын гэмт хэргийн статистик мэдээлэлд гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг шүүхийн шийдвэрээр хураан авсан талаарх тусгайлсан тоон үзүүлэлт тусгагдаагүй байна.

Түүнчлэн, 2013-2017 онд Авлигатай тэмцэх газраас мөрдөн шалгах ажиллагаа явуулсан эрүүгийн хэргийн улмаас нийт 299.8 тэрбум төгрөгийн хохирол учирснаас 20.3 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, 85.7 тэрбум төгрөгийн хөрөнгийг битүүмжилжээ. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн мэдээллээр мөн хугацаанд гэмт хэрэг үйлдэж олсон 400 сая төгрөгийн хөрөнгө, орлогыг хураан авсан нь албан тушаалын гэмт хэргийн улмаас учирсан нийт хохирлын 0.1 хувь, битүүмжилсэн хөрөнгийн үнийн дүнгийн 0.4 хувьтай тус тус тэнцэж байна. Энэ нь гэмт хэргийн улмаас учирсан хохирол, битүүмжилсэн хөрөнгийн хэмжээтэй харьцуулахад бодитоор хураан авч, улсын орлого болгосон хөрөнгийн хэмжээ үлэмж бага байгааг харуулж байна.

7.Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураан авах эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийхэд 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн Эрүүгийн хуулийн 7.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүх энэ хуулийн 5.1 дүгээр зүйлд заасан ялын зорилгыг хангахад шаардлагатай гэж үзвэл гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахгүйгээр тэнсэж, эсхүл оногдуулсан ял дээр нэмж дараах албадлагын арга хэмжээг хэрэглэж болно” гэж заасан бөгөөд мөн хуулийн 7.5 дугаар зүйлд гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогын ойлголт болон түүнд авах албадлагын арга хэмжээг зохицуулсан байна. Гэвч уг зохицуулалтаар гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг бүх тохиолдолд заавал хураах, учирсан хохирлыг заавал нөхөн төлүүлэх нийтлэг шаардлагыг шууд тогтоогоогүй байна. Харин 2002 онд батлагдан мөрдөгдөж байсан Эрүүгийн хуулийн 49 дүгээр зүйлд гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг эд хөрөнгө хураах ял оногдуулсан эсэхээс үл хамааран заавал хураахаар зохицуулж байжээ.

Иймд гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг илрүүлэх, битүүмжлэх, хураан авах, улсын орлого болгох болон учирсан хохирлыг нөхөн төлүүлэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах боломжгүй болсон, ял шийтгэл оноох боломжгүй тохиолдолд ч гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг буюу хууль бус хөрөнгийг тухайн этгээдийн өмчлөл, эзэмшилд үлдээхгүй байх эрх зүйн механизмыг боловсронгуй болгох шаардлага бий болоод байна.

Түүнчлэн Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг, эсхүл бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор гэмт хэргийн улмаас учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хувьд ногдох хөрөнгө, орлогоос албадан гаргуулна.” гэж, 2 дахь хэсэгт “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого” гэж Монгол Улсад бол энэ хуулийн тусгай ангид заасан, гадаад улсад бол тухайн улсын хуулиар нэг жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдэж шууд, шууд бусаар олсон эдийн, эдийн бус хөрөнгө, түүний үнэ, түүнээс олсон ашиг, орлого, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, ашиглахаар завдсан техник, хэрэгслийг ойлгоно.” гэж, 3 дахь хэсэгт “Хураан авсан хөрөнгө, орлогыг бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх, хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны зардалд зарцуулна. Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогын хэмжээ нь

хохирлоос илүү гарсан тохиолдолд улсын төсөвт шилжүүлнэ.” гэж, 4 дэх хэсэгт “Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл, түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, уналга, галт зэвсэг, зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл нь тухайн гэм буруутай этгээдийн өмчлөлд байсан нь тогтоогдсон тохиолдолд түүнийг хураан авч хадгалах, устгах, гэмт хэргийн хохирол нөхөн төлөхөд зарцуулна.” гэж, 5 дахь хэсэгт “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого хууль ёсны дагуу хийгдсэн хэлцлийн үндсэн дээр бусдын өмчлөлд шилжсэн бол шүүх тухайн эд зүйлийг үнэлж гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хувьд ногдох, хураан авахыг хуулиар хориглоогүй хөрөнгө, орлогоос албадан гаргуулж хохирлыг төлүүлнэ. Тухайн хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдэж олсон болохыг мэдсээр байж авсан болох нь тогтоогдвол шүүх уг эд зүйл, хөрөнгө, орлогыг бусдын өмчлөлд шилжүүлсэн хэлцлийг хүчингүйд тооцож, хөрөнгө, орлогыг хураан авч хохирлыг нөхөн төлүүлнэ.” гэж, 6 дахь хэсэгт “Шүүх хөрөнгө, орлого хураан авахдаа хураан авах хөрөнгө, орлогыг шийдвэртээ нэг бүрчлэн заана.” гэж, мөн хуулийн 1.10 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссанаас үл хамааран шүүхийн шийдвэрээр хурааж улсын орлого болгоно.” гэж заасан.

Гэвч эдгээр зохицуулалт нь үндсэндээ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийн гэм бурууг тогтоосон шийдвэртэй уялддаг тул сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нас барсан, оргон зайлсан, сураггүй алга болсон, халдашгүй байдлын улмаас яллах боломжгүй болсон, эсхүл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд заасан бусад үндэслэлээр эцэслэсэн, эсхүл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах үндэслэлгүй, боломжгүй болсон тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураах боломжгүйд хүрдэг.

8.Авлигын зөрчлийн улмаас бий болсон хөрөнгө, орлогыг гэр бүл, төрөл садан, хамаарал бүхий этгээд, хуулийн этгээд, итгэмжлэгдсэн өмчлөгч, эцсийн өмчлөгчийн нэрээр бүртгүүлэх, хэлбэр төдий буюу бусад хэлцлийг халхавчлах зорилгоор дүр үзүүлэн хийсэн хэлцлээр шилжүүлэх, хууль ёсны болон хууль бус хөрөнгийг хольж нэгтгэх, гадаад улсад байршуулж нуун далдлах тохиолдолд хөрөнгийн бодит өмчлөгч, хяналт хэрэгжүүлэгчийг тогтоох, орлуулан хураах хөрөнгийн үнийг тооцох, шударга гуравдагч этгээдийн эрхийг хамгаалах зохицуулалт мөн шаардлагатай байна.

9.Хөрөнгө хураах ажиллагаа нь өмчлөх эрхэд нөлөөлөх тул хууль зүйн туслалцаа авах, баримттай танилцах, тайлбар гаргах, шинжээч томилуулах, гэрчлүүлэх, нотлох баримтыг няцаах, шүүх хуралдаанд оролцох, шийдвэрийг давж заалдах, үндэслэлгүйгээр битүүмжилсэн болон хураасан хөрөнгийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх зэрэг процессын баталгааг хуульд нарийвчлан тогтоох шаардлагатай. Мөн өөрийн болон гэр бүлийн гишүүнийхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийн зарчимд сөрөг үр дагавар үүсгэхгүй байх заагийг тодорхой болгоно.

Эдгээр асуудлыг байгууллагын журам, заавар, захиргааны зохион байгуулалтын арга хэмжээгээр нөхөх, шийдвэрлэх боломжгүй юм. Учир нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална” гэж баталгаажуулсан.

10.Хөрөнгө хураах нь зөвхөн эрүүгийн механизмын асуудал биш бөгөөд зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураах асуудал Зөрчлийн тухай хууль тогтоомжоор, мөн авлигын зөрчил буюу Авлигын эсрэг хуульд заасан хориглосон

үйлдлийг үйлдэж олсон хөрөнгө, орлого болон нийтийн албан тушаалтны үндэслэлгүй хөрөнгөжсөн 100 сая хүртэл төгрөгний хөрөнгийг хураах асуудал Авлигын эсрэг хуульд тусгагдсан.

Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгийг Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар, зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудаар зохицуулж байгаа бол Авлигын эсрэг хуульд заасан хориглолтыг зөрчсөний улмаас олсон хөрөнгө, орлогыг хураах механизм нарийн тодорхой хуульчлагдаагүй байна.

11.Сүүлийн жилүүдэд эрх бүхий байгууллагад бүртгэгдэж, шүүхээс таслан шийдвэрлэгдсэн авлигын, ялангуяа нийтийн албан тушаалтан хахууль авах гэмт хэргүүдээс үзэхэд, гэмт этгээд бусдаас тэрбум, түүнээс дээш хэмжээний хахууль авсан болох нь тогтоогдож, иргэдийг ихээр бухимдуулж байна. Эрүүгийн хуульд нийтийн албан тушаалтан их хэмжээний хахууль буюу нэг зуун сая төгрөгөөс дээш хэмжээний хахууль авсан бол тухайн этгээдэд Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгээр зүйлчилж, эрүүгийн хариуцлага хүлээлгэж байгаа бөгөөд тодруулбал, нэг зуун сая төгрөгийн хахууль авсан, нэг зуун тэрбум төгрөгийн хахууль авсан этгээдийн үйлдэлд Эрүүгийн хуулийн адил зүйл, хэсгээр зүйлчилж, адил ял оногдуулж байна. Энэ нь Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна.” гэж заасан шударга ёсны зарчимтай нийцэхгүй бөгөөд “онц их хэмжээний” буюу тэрбум түүнээс дээш хэмжээний хахууль авсан нийтийн албан тушаалтны үйлдлийг хүндрүүлэн зүйлчилж, хүлээлгэх ялыг чангатгах шаардлагатай байна.

Түүнчлэн тус гэмт хэргийн шинжийг “Нийтийн албан тушаалтан хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албаны чиг үүргээ хэрэгжүүлсний хариуд, эсхүл хэрэгжүүлэхийн тулд, эсхүл хэрэгжүүлээгүйн хариуд, эсхүл хэрэгжүүлэхгүй байхын тулд, эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийсэн, эсхүл хийхийн тулд шууд, эсхүл бусдаар дамжуулан хахууль өгөхийг шаардсан, авсан бол ..” гэж Эрүүгийн хуульд тодорхойлсон нь нийтийн албан тушаалтан хээл хахуулийг өөртөө авалгүйгээр “төлөөний хүн”-д хээл хахуулийг өгүүлсэн үйлдэл нь тус гэмт хэргийн шинжид хамаарахгүй байх нөхцөлийг бүрдүүлж, тус гэмт хэргийг үйлдэгч нарт ял оноох, хариуцлага ногдуулах боломжгүй хийдэлтэй зохицуулалт болсон гэж үзэхээр байна.

Түүнчлэн сүүлийн жилүүдэд нийтийн албан тушаалтнаас бусад этгээд хахууль авах гэмт хэргийн гаралт, хахуулийн хэмжээ, гэмт этгээд энэ гэмт хэргийг хясан боогдуулах аргаар үйлдэх байдал нэмэгдэх хандлагатай байна.

Иймд нийтийн албан тушаалтнаас бусад этгээд хахууль авах гэмт хэргийг хясан боогдуулах аргаар үйлдсэн, эсхүл их хэмжээний хахууль авсан, энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн, эсхүл онц их хэмжээний хахууль авсан бол эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх мөн шаардлагатай байна.

12.Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийг хэлбэрийн шинжтэйгээр /хохирлын хэмжээ шаардахгүй/ хуульчилсан нь хохирол их, багаас үл хамааран адилхан ял шийтгэл хүлээхээр байгаа нь Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна.” гэж заасан шударга ёсны зарчимтай мөн нийцэхгүй байна.

13. Нийтийн албан тушаалтан албан үүрэгтээ хайнга хандах гэмт хэрэг нь гэм буруугийн болгоомжгүй хэлбэрээр үйлдэгдэх гэмт хэрэг хэдий ч энэ гэмт хэргийн субъектив талын шинжид гэм буруугийн хэлбэрийг тодорхой зааж өгөөгүйн улмаас практикт хайнга хандах гэмт хэргийг эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах (22.1) гэмт хэргээс ялган зүйлчлэхэд хүндрэл учруулж байна. Мөн 2002 оны Эрүүгийн хуулийн 272 дугаар зүйлд албан тушаалын гэмт хэрэгт бүлэгт хуульчилж байсан уламжлал, Оросын Холбооны Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Эрүүгийн хуульд хайнга хандах гэмт хэргийг авлига, албан тушаалын гэмт хэргийн бүлэгт хуульчилсан туршлага, энэ төрлийн гэмт хэргийн онцлог, нийтийн албан тушаалтан ихэвчлэн үйлддэг байдлыг харгалзан Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт хуульчлах шаардлагатай байна.

Мөн практикт Эрүүгийн хуулийн 23.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 15.1 дүгээр зүйлд заасан эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байх гэмт хэргээс ялган зүйлчлэхэд хүндрэл учирдаг. Тус гэмт хэргийг эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргээс ялган зүйлчлэхэд хүндрэл учруулж, авлигын гэмт хэрэг үйлдсэн нийтийн албан тушаалтан хөнгөн ял шийтгэгдэх, улмаар нийтийн албанд ажиллах, хууль тогтоох дээд байгууллагын сонгуульд нэр дэвших боломжийг бүрдүүлсэн хийдлийг засах шаардлагатай болжээ.

14. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдлийн үнэлгээгээр¹ манай улсад мөнгө угаах гэмт хэрэгтэй холбогдох эрсдэлтэй гэмт хэргийг үнэлсэн бөгөөд уг үнэлгээгээр 1.авлигын, залилах, кибер орчинд хууль бусаар халдах гэмт хэргүүд өндөр эрсдэлтэй, 2.татвар төлөхөөс зайлсхийх, хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргүүд дунд эрсдэлтэй, 3.хөрөнгө завших, хулгайлах, мал хулгайлах гэмт хэргүүд бага-дунд эрсдэлтэй, 4.улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх, хууль бусаар ан агнах, хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргүүд бага эрсдэлтэй гэж дүгнэжээ.

Гэвч мөнгө угаах гэмт хэргийг сүүлийн 4 жил эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс 193 хүнд холбогдох 172 хэргийг шийдвэрлэжээ.² Нийт суурь гэмт хэргээс өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 154 буюу 90.5 хувийг, эдийн засгийн гэмт хэрэг 2 буюу 1 хувийг, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 1 буюу 0.5 хувийг, авлигын гэмт хэрэг 5 буюу 2.7 хувийг, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 5 буюу 2.7 хувийг, кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 4 буюу 2.3 хувийг, цэргийн албаны эсрэг гэмт хэрэг 1 буюу 0.5 хувийг тус тус эзэлж байна. Эндээс үзэхэд, мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийн дийлэнх хувийг өмчлөх эрхийн эсрэг(хулгайлах, мал хулгайлах, залилах, дээрэмдэх) гэмт хэрэг эзэлж байна.

Мөнгө угаах гэмт хэргээр нийт 193 хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэснээс бусдын үйлдсэн гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, орлогыг угаасан хүн 160 буюу 83 хувийг, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогоо өөрөө угаасан хүн 33 буюу 17 хувийг тус тус эзэлж байгаа судалгаа байна.

¹ Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдлийн үнэлгээ. Уб., 2020

² Б.Батцэрэн. Мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийг тогтоох аргачлал, ял оногдуулах асуудал. Мөнгө угаах гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа: Тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Уб., 2024. 43 дахь тал

2015 оны Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлд мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэгт бүх гэмт хэргийг хамаарахаар хуульчилсан атал зөвхөн дээр дурдсан өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргүүдийн хүрээнд яллах дүгнэлт үйлдэж, шүүхэд шилжүүлэх практик тогтсон гэж үзэж болохоор байна.

Иймд мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийг олон улсын гэрээ, конвенц, ФАТФ-ын зөвлөмж, суурь гэмт хэргийг тодорхойлох олон улсын аргачлалыг харгалзан оновчтой тодорхойлох, бусдын үйлдсэн гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, орлогыг угаах, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогоо өөрөө угаах үйлдлийг ялгамжтай байдлаар хуульчлах, энэ гэмт хэргийг виртуал хөрөнгө ашиглаж, хуулийн этгээдийг халхавчаар ашиглаж, үндэстэн дамнаж үйлдсэн бол нийгмийн аюулын шинжийг харгалзан хүндрүүлэх бүрэлдэхүүнд шинээр хуульчилах шаардлагатай байна.

15.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1-д "Тухайн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, шүүх бүрэлдэхүүнд аливаа этгээдээс нөлөөлөхөөр оролдсон бүх тохиолдлыг тэмдэглэн баталгаажуулж нөлөөллийн мэдүүлэг хөтөлнө." гэж заасан.

Шүүхийн хараат бус, бие даасан байдлыг хангах, шүүгч, шүүх бүрэлдэхүүнд аливаа этгээд нөлөөлөх байдлыг таслан зогсоох зорилгоор Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлгийн 22.16 дугаар зүйлд шүүгч хуульд заасны дагуу нөлөөллийн мэдүүлэг хөтлөөгүй, эсхүл бүрэн бус, худал хөтлөх үйлдлийг гэмт хэрэгт тооцох замаар, мөн шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч, иргэдийн төлөөлөгчид хууль бусаар нөлөөлөх (Эрүүгийн хуулийн 21.6 дугаар зүйл) гэмт хэргийн объектив талын шинжид эдгээр албан тушаалтанд бусад байдлаар нөлөөлөхийг оролдсон, нөлөөлсөн үйлдлийг нэмж, тус зүйлийн хууль тогтоогчийн тайлбарт заасан улс төрд нөлөө бүхий этгээдэд хамаарах албан тушаалд ажиллаж байгаа болох өмнө нь ажиллаж байсан хүнийг ойлгохоор хүрээг өргөжүүлэн нэг талаас шүүгчийг нөлөөллөөс хамгаалах, нөгөө талаас дээрх хуулийн заалтыг хэрэгжүүлэх хөшүүрэг бий болгох шаардлагатай байна.

Иймд дээр дурдсан хууль зүйн болон практик хэрэгцээ, шаардлагыг үндэслэн авлигын хөрөнгийг эрүүгийн ял, зөрчлийн шийтгэлээс тусдаа буюу яллахгүйгээр, мөн шийтгэл оноохгүйгээр хуульд заасан үндэслэл, журмаар, эрх бүхий этгээдийн ажиллагаагаар хууль бус хөрөнгө шалгах, хураах, мөн шалгах ажиллагаа нь прокурорын хяналтад байх, хууль бус хөрөнгийг зөвхөн шүүхийн шийдвэрээр хураан авах, улмаар хөрөнгийн үнэ цэнийг хамгаалах, хохирлыг нөхөн төлүүлэх, хураан авсан хөрөнгийг ил тод, хариуцлагатайгаар зохистой захиран зарцуулах харилцааг цогцоор нь зохицуулсан анхдагч хуулийн төсөл боловсруулах нь зүйтэй байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийн зорилгыг авлигын хөрөнгийг хураан авч улсын орлого болгох, хохирогчид олгох, төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, сэргээх, хууль бус хөрөнгөжилтөөс урьдчилан сэргийлэх, авлигагүй улс болоход чиглүүлнэ.

Яллахгүйгээр, шийтгэл оноохгүйгээр хууль бус хөрөнгийг хураах асуудлыг шийдвэрлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх үүднээс энэхүү хуулийн төсөлд хуулийн үйлчлэлд хамаарах авлигын хөрөнгө, албан тушаалтны хүрээ, авлигын буюу

зорилго хууль бус хөрөнгийг шалгах ажиллагаа, тус ажиллагаа прокурорын хяналтад байх, хураан авах тухай нэхэмжлэл гаргах, уг нэхэмжлэлийг шүүхээр хянан шийдвэрлэх, түр хураасан хөрөнгийг хамгаалах, үнэлэх, хадгалах, хууль бус хөрөнгийг гагцхүү шүүхийн шийдвэрээр хураан авч улсын орлого болгох, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хураасан хөрөнгийг эрхлэн удирдах, худалдах, түрээслэх, төрийн байгууллагад шилжүүлэх, зориулалтын дагуу ашиглуулах, устгах, эдгээр ажиллагаанаас олсон орлогыг Засгийн газрын тусгай сан буюу Хүүхэд, залуучуудын хөгжлийн санд төвлөрүүлэх, зарцуулах, бүртгэх, тайлагнах, олон нийтэд мэдээлэхтэй холбогдсон харилцааг цогцоор нь тусгана.

Авлигын буюу хууль бус хөрөнгө хураах ажиллагаа нь албан тушаалтан хөрөнгийг хууль бусаар олж авсан болох нь тогтоогдсон, эсхүл хөрөнгийг хууль ёсны дагуу олж аван болохыг үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй байгаа хөрөнгийг хураах шийдвэрийг шүүх гаргах, уг хөрөнгийг төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хохирогчийн зөрчигдсөн эрхийг сэргээхэд чиглэсэн тусгай эрх зүйн арга хэмжээ болно. Энэ хуулийн төсөл нь гэм бурууг тогтоох, ял, шийтгэл оногдуулах, эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлийг шинээр тогтоохгүй бөгөөд авлига, албан тушаалын гэмт хэрэг, авлигын зөрчлийн улмаас бий болсон хөрөнгө, орлогыг буцаан авах, хураан авах ажиллагааг хүний эрх, өмчлөх эрх, шударга эзэмшигчийн эрх, хохирогчийн хохирол нөхөн төлүүлэх эрхийг хамгаалсан журмаар хэрэгжүүлэхэд чиглэнэ.

Хуулийн үйлчлэлд Авлигын эсрэг хуульд заасан нийтийн албан тушаал эрхэлж байгаа болон эрхэлж байсан хүн, түүнчлэн Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлгийн 22.13/Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах/, 22.14/Хахууль авах/ дүгээр зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн этгээд, мөн хууль бус хөрөнгийг түүний ашиг сонирхлын төлөө өмчилж, эзэмшиж, ашиглаж, хадгалж, нуун далдалж, шилжүүлэн авсан хамаарал бүхий болон нэгдмэл сонирхолтой этгээд хамаарна. Албан тушаалтны шууд болон шууд бус өмчлөл, эзэмшилд байгаа, хууль ёсны орлогын эх үүсвэрээс давсан, хууль ёсны дагуу олж авсан болохыг үндэслэлтэйгээр тайлбарлаж чадахгүй, гэмт хэрэг, зөрчил, авлигын болон ашиг сонирхлын зөрчлийн улмаас бий болсон хөрөнгө, түүнээс олсон үр шим, мөн уг хөрөнгийг өөрчлөх, хувиргах, бусад хөрөнгөтэй холих, нийлүүлэх замаар бий болгосон хөрөнгийн хууль бус хэсгийг хуулийн зохицуулах хүрээнд хамруулна.

Хууль бус хөрөнгийг тухайн хөрөнгөөр нь хураах боломжгүй болсон, бусдад шилжүүлсэн, нуусан, устгасан, зарцуулсан, хэлбэрийг нь өөрчилсөн тохиолдолд хөрөнгийн үнэ болон түүнээс олсон үр шимийг нөхөн төлүүлэхээр зохицуулна. Хөрөнгийн үнийг нөхөн төлүүлэхдээ хууль бус хөрөнгө бий болсон үеийн болон түүнийг захиран зарцуулсан үеийн зах зээлийн үнэлгээг харгалзан, хөрөнгийн үнэ цэнийн бууралтаас төр, нийтийн ашиг сонирхолд хохирол учруулахгүй байх зарчмыг баримтална.

Хөрөнгө, орлогыг буцаан авах, хураан авах ажиллагаанд хууль дээдлэх, хүний эрх, өмчлөх эрх, шударга шүүхээр шүүлгэх эрхийг хангах, гэм буруугүйд тооцох зарчмыг хүндэтгэх, уг ажиллагааг шүүхийн хяналттай хэрэгжүүлэх, нэхэмжлэгч тухайн хөрөнгө нь гэмт хэрэг, зөрчил, хувийн ашиг сонирхлын шинжтэй хориглолт, хязгаарлалтад хамаарах зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлого, түүний үр шим, хувирсан хэлбэр болохыг үндэслэл бүхий нотлох баримтаар нотолсний үндсэн дээр нэхэмжлэх, мөн нийтийн албан тушаалтан хууль ёсны орлогоосоо давсан хөрөнгийг хууль ёсны дагуу олж авсан болохыг тайлбарлаж чадахгүй бол тухайн хөрөнгийг хууль бус гэж үзэж нэхэмжлэх, хариуцагч болон гуравдагч этгээдэд тайлбар, нотлох баримт гаргах, шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхийг

эдлүүлэх, шударга эзэмшигч, барьцаалагч, хамтран өмчлөгч, өмнөх хууль ёсны өмчлөгч, хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, гэмт хэрэг, зөрчил, хууль бус үйлдлийн улмаас учирсан хохирол, хор уршгийг тэргүүн ээлжид нөхөн төлүүлэх, хөрөнгө хураах болон нөхөн төлүүлэх арга хэмжээг тухайн хөрөнгийн хууль бус эх үүсвэрт ногдох хэсгээр хязгаарлах, хууль бусаар олж авсан хөрөнгийг нуух, шилжүүлэх, хувиргах, бусдын нэр дээр байршуулснаар хариуцлагаас зайлсхийх боломж олгохгүй байх зарчмыг баримтална.

Хууль ёсны орлогоос давсан бөгөөд хууль ёсны олж авсан болох нь тодорхойгүй хөрөнгө илэрсэн, хариуцагч тайлбар гаргаагүй, эсхүл гаргасан тайлбар нь хангалтгүй гэж үзэгдсэн нөхцөл нь дангаараа тухайн хөрөнгийг хууль бусад тооцож хураах үндэслэл болохгүй бөгөөд шүүх нэхэмжлэгчийн гаргасан нотлох баримт болон хариуцагч, гуравдагч этгээдийн тайлбар, нотлох баримтыг тал бүрээс нь бодитой үнэлж шийдвэрлэнэ.

Хууль бус хөрөнгийг зах зээлийн бодит үнэ төлж, хөрөнгийн хууль бус шинжийг мэдээгүй, мэдэх боломжгүйгээр шилжүүлэн авсан этгээдийг шударга эзэмшигчид тооцож, түүний өмчлөх эрхийг хамгаалах зарчим бариталж хуульчилна. Харин хууль бус хөрөнгийг өв залгамжлал, бэлэглэл, гэрээслэл болон бусад хариу төлбөргүй хэлцлээр, эсхүл хөрөнгийн жинхэнэ өмчлөгч, эзэмшигчийг нуун далдлах зорилгоор дүр үзүүлэн хийсэн хэлцлийн үндсэн дээр шилжүүлэн авсан бол тухайн хөрөнгийг хураах боломжтой байхаар зохицуулна. Шударга эзэмшигчийн өмчлөлд шилжсэн хууль бус хөрөнгийг хураахгүй бөгөөд уг хөрөнгийн үнэ, түүнээс олсон үр шимийг нийтийн албан тушаалтан болон хуульд заасан холбогдох этгээдээр нөхөн төлүүлнэ.

Хуулийн төслийг Авлигын хөрөнгийг хурааж, хүүхэд, залуучуудын хөгжлийн санд төвлөрүүлж зарцуулах тухай нэртэйгээр анхдагч хуулийн төсөл хэлбэрээр боловсруулах ба хуулийн төсөл дараах үндсэн бүтэцтэй байна. Үүнд:

1/нэгдүгээр бүлэгт хуулийн зорилго, зорилт, хууль тогтоомж, үйлчлэх хүрээ, нэр томъёоны тодорхойлолт;

2/хоёрдугаар бүлэгт хууль бус хөрөнгө шалган шийдвэрлэх ажиллагаа, түүний зарчим, хууль бус хөрөнгө шалган шийдвэрлэх ажиллагааны хэл бичиг, хугацаа тоолох, нууцлал, зардал, гомдол, хүсэлт гаргах талаар;

3/гуравдугаар бүлэгт хууль бус хөрөнгө шалган шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч буюу Авлигатай тэмцэх газар, прокурор, шүүхийн байгууллагын бүрэн эрх, татварын алба, Санхүүгийн мэдээллийн албаны чиг үүрэг;

4/дөрөвдүгээр бүлэгт хууль бус хөрөнгө шалган шийдвэрлэх ажиллагааны оролцогч буюу холбогдогч, өмгөөлөгч, орчуулагч, хэлмэрч, гэрч, хөндлөнгийн гэрч, шинжээч, мэргэжилтэн, хөрөнгийн үнэлгээчин, иргэний нэхэмжлэгч;

5/тавдугаар бүлэгт хууль бус хөрөнгө шалгах тодорхой ажиллагаа явуулах журам буюу тодорхой ажиллагааны төрлүүд, тухайлбал, үзлэг, нэгжлэг хийх, түр хураан авах, битүүмжлэх, түр хураан авсан хөрөнгийн эрхлэн удирдлага, хамгаалалт, хадгалалт, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, хянах, тайлбар, мэдүүлэг авах, дуудан ирүүлэх, шалгах нууц ажиллагаа, хэргийг нэгтгэх, тусгаарлах гэх мэт ажиллагаа, прокурорын зөвшөөрөл;

6/зургаадугаар бүлэгт эрх хязгаарлах арга хэмжээ буюу Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх, үнэт цаасны арилжааг тор зогсоох, үнэт цаас тусгаарлах;

7/долоодугаар бүлэгт хууль бус хөрөнгө шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах журам, гомдол, мэдээлэл хүлээн авах, хууль бус хөрөнгөө өөрөө илчлэн мэдээлэх, гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлэх, гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзах, хэрэг нээх, хялбаршуулсан журмаар шийдвэрлэх, хөрөнгө шалгах ажиллагааны хугацаа, түүний сунгалт, хэрэг танилцуулах, ажиллагааг дуусгах, хэргийг хэрэгсэхгүй болгох, прокурорт нэхэмжлэл гаргах санал хүргүүлэх, шалгах ажиллагааны баримт бичиг, хэргийн материал;

8/наймдугаар бүлэгт хууль бус хөрөнгө шалгах ажиллагаанд тавих прокурорын хяналт, шийдвэр, хөрөнгө хураан авах, нөхөн төлүүлэх нэхэмжлэл гаргах;

9/есдүгээр бүлэгт хууль бус хөрөнгийг хянан шийдвэрлэх шүүхийн ажиллагаа, шүүхийн шийдвэр;

10/аравдугаар бүлэгт олон улсын хамтын ажиллагаа, хүсэлт илгээх журам, хууль бус хөрөнгийг буцаан олгох, хуваарилах;

11/арван нэгдүгээр бүлэгт хураасан хөрөнгийг эрхлэн удирдах байгууллагын тогтолцоо, Хөрөнгө эрхлэн удирдах зөвлөл болон Хөрөнгө хамгаалах албаны бүрэн эрх;

12/арван хоёрдугаар бүлэгт хурааж улсын орлого болгосон авлигын хөрөнгийг Засгийн газрын тусгай сан буюу Хүүхэд, залуучуудын хөгжлийн санд төвлөрүүлэх, хүн амын эрүүл мэнд, боловсролын тодорхой арга хэмжээг санхүүжүүлэхтэй холбоотой харилцаа;

13/арван гуравдугаар бүлэгт мэдээллийн сан, тайлан, бусад холбогдох харилцааг тус тус тусган боловсруулна.

Гурав.Хууль батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, авах арга хэмжээ

Хуулийн төсөл батлагдсанаар Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7, 7.1.8 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.2 дахь заалтыг хэрэгжүүлэх буюу нийтийн албан тушаалтнуудын хууль ёсны бус хөрөнгөд хамаарах хөрөнгийн шинж, түүнийг хэрэгжүүлэх механизм тодорхой болж, авлигын хөрөнгийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр дүнгээс дангаар хамааралгүйгээр, иргэний хэрэг хянан шийдвэрлэх журмаар шүүхийн хяналттай хураах буюу ял, шийтгэл оноохгүйгээр авлигын буюу хууль бус хөрөнгө хураах эрх зүйн үндэс эхний ээлжинд бүрдэнэ. Ингэснээр гэмт хэрэг, зөрчил хөөн хэлэлцэх хугацаа дууссан, холбогдох этгээд нас барсан, өршөөлд хамрагдсан, эрүүгийн болон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэх боломжгүй болсон, эсхүл хэргийг эцэслэн шийдвэрлэхдээ гэмт хэрэг, зөрчил үйлдэж олсон хөрөнгийг хураагаагүй тохиолдолд хууль бус хөрөнгийг тухайн албан тушаалтан болон түүний хамаарал бүхий этгээдийн өмчлөл, эзэмшилд үлдээхгүй байх эрх зүйн боломж бүрдэнэ.

Хууль зүйн үр дагаврын хувьд хууль бус хөрөнгийн ойлголт, хамрах хүрээ, хөрөнгө хураах нэхэмжлэл гаргах үндэслэл, нэхэмжлэл гаргах эрх бүхий

байгууллага, шүүхийн харьяалал, талуудын эрх, үүрэг, нотлох баримтын шаардлага, хөрөнгийн үнэ цэнийг түр хамгаалах арга хэмжээ, шударга эзэмшигчийн эрхийн баталгаа, хураах болон нөхөн төлүүлэх шийдвэрийн төрөл, шийдвэр гүйцэтгэх, хураасан хөрөнгийг эрхлэн удирдах ажиллагааны эрх зүйн үндэс тодорхой болно. Мөн Авлигатай тэмцэх газар, прокурор, шүүх, татварын алба, санхүүгийн мэдээллийн алба, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харилцан ажиллагааны зааг тогтоогдож, нэг асуудлыг өөр өөр байгууллага давхардуулан шалгах, эсхүл аль ч байгууллага хариуцахгүй орхигдуулах эрсдэл буурна.

Нийгмийн үр дагаврын хувьд хууль бусаар хөрөнгөжих замаар олсон эдийн засгийн үр өгөөжийг тухайн этгээдэд үлдээхгүй байх зарчим хэрэгжиж, авлига, ашиг сонирхлын зөрчилд үл тэвчих нийгмийн хандлага төлөвших, нийтийн албан тушаалтны хариуцлага нэмэгдэх, иргэдийн төрийн байгууллага, хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагад итгэх итгэлийг сэргээхэд эерэг нөлөө үзүүлнэ. Хураан авсан хөрөнгийг хохирол нөхөн төлүүлэхэд тэргүүн ээлжид зарцуулах нь хохирогчийн зөрчигдсөн эрхийг бодитоор сэргээх нөхцөлийг бүрдүүлнэ. Хөрөнгө эрхлэн удирдах ажиллагаанаас олсон орлогыг хүн амын эрүүл мэнд, боловсролын бүтээн байгуулалтыг дэмжихэд зарцуулснаар хууль бус хөрөнгийг нийтийн ашиг сонирхолд буцаан чиглүүлэх боломж бүрдэнэ.

Эдийн засгийн үр дагаврын хувьд хууль бус хөрөнгө болон түүнээс олсон үр шимийг улсын орлого болгох, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх хэмжээ нэмэгдэж, хууль бус хөрөнгийг нуух, бусдад шилжүүлэх, хэлбэрийг нь өөрчлөх эдийн засгийн сонирхол буурах нөхцөл бүрдэнэ. Түр болон бүр хураасан хөрөнгийг мэргэшсэн байгууллагаар хадгалж, хамгаалах, түргэн муудах, хадгалалтын өндөр зардалтай хөрөнгийг шүүхийн хяналттайгаар зах зээлийн үнээр худалдах, мөнгөн хөрөнгийг хүүтэй хадгалуулах, борлогдоогүй хөрөнгийг түрээслэх, төрийн байгууллагын үйл ажиллагаанд ашиглуулах замаар хөрөнгийн үнэ цэнэ буурах, үрэгдэх, ашиглалгүй удах эрсдэлийг багасгана.

Хуулийг хэрэгжүүлэхэд Хөрөнгө эрхлэн удирдах зөвлөл болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын Хөрөнгө хамгаалах албыг байгуулах, тэдгээрийн орон тоо, хүний нөөц, байр, агуулах, тусгай зориулалтын хадгалалтын байгууламж, хамгаалалтын тоног төхөөрөмж, үнэлгээ, цахим бүртгэл, мэдээллийн системийг бүрдүүлэхтэй холбоотой төсвийн зардал үүснэ.

Иймд хуулийн төслийн зардлын тооцоонд шинээр байгуулах нэгжийн бүтэц, орон тоо, цалин хөлс, хөрөнгө хадгалах болон хамгаалах байр, тээвэрлэлт, даатгал, үнэлгээ, дуудлага худалдаа, мэдээллийн систем, сургалт, аюулгүй ажиллагаа, хөрөнгө устгах болон бусад тогтмол, хувьсах зардлыг дэлгэрэнгүй тооцож, улсын төсөв болон тусгай сангийн орлогоор санхүүжүүлэх зардлын заагийг тодорхойлох шаардлагатай.

Хууль хэрэгжиж эхлэхээс өмнө Авлигатай тэмцэх газар, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон бусад оролцогч байгууллагын мэдээллийн санг харилцан уялдуулах, хөрөнгийн хөдөлгөөнийг анх хүлээн авсан үеэс эцсийн байдлаар захиран зарцуулах хүртэл шалган бүртгэх цахим систем бий болгох, мэдээллийн бүрэн бүтэн байдал, нууцлал, кибер аюулгүй байдлыг хангах, мэдээлэлд нэвтрэх эрхийн түвшин болон олон нийтэд мэдээлэх мэдээллийн хүрээг нарийвчлан тогтоох шаардлагатай.

Түүнчлэн, хөрөнгө илрүүлэх, санхүүгийн шалгах ажиллагаа явуулах, хөрөнгийн хууль ёсны эх үүсвэрийг үнэлэх, холимог хөрөнгийн хууль бус хэсгийг

тооцох, виртуал болон биет бус хөрөнгө, үнэт цаас, компанийн хувьцаа, гадаад улсад байгаа хөрөнгийн үнэлгээ, хөдөлгөөнийг тогтоох чиглэлээр эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүгч, шийдвэр гүйцэтгэгч, шинжээч, үнэлгээчин болон хөрөнгө эрхлэн удирдах ажилтныг мэргэшүүлэх сургалтыг үе шаттай зохион байгуулна.

Өмчлөх эрхэд хууль бусаар болон хэт өргөн хүрээгээр халдах эрсдэлийг бууруулахын тулд нэхэмжлэл гаргах нотлох баримт бүрдүүлэх, талуудын нотлох үүргийн хуваарилалт, хууль ёсны орлогыг тайлбарлах боломжит хугацаа, нотлох баримттай танилцах, тайлбар гаргах, өмгөөлөгч авах, шинжээч томилуулах, шүүхийн шийдвэрийг давж заалдах эрх, шударга эзэмшигчийн эрхийн баталгаа, хураахгүйгээр шийдвэрлэсэн хөрөнгө болон борлуулалтын орлогыг хүүгийн хамт буцаан олгох асуудал хуульчлагдана. Монгол Улсын Үндсэн хууль өмчлөх эрх, шударга шүүхээр шүүлгэх, нотлох баримтыг шалгуулах, шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхийг баталгаажуулдаг тул эдгээр баталгааг хууль бус хөрөнгө шалган шийдвэрлэж хураах ажиллагааны бүх үе шатанд хангах шаардлагатай.

Хууль хүчин төгөлдөр болохоос өмнө хөрөнгө эрхлэн удирдах байгууллагын бүтэц, ажиллах журам, хөрөнгө хүлээн авах, үнэлэх, хадгалах, хамгаалах, даатгах, худалдах, түрээслэх, бусад байгууллагад шилжүүлэх, устгах, орлогыг тусгай санд төвлөрүүлэх, бүртгэх, тайлагнах, мэдээлэх журмыг баталж, шаардлагатай төсөв, хүний нөөц, техник хэрэгсэл, мэдээллийн системийг бүрдүүлсэн байна.

Авлигын гол зорилго болох хууль бус хөрөнгийг хураах нь нийтийн албан тушаалтнуудын авлига, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх, шударга ёсыг хангах, иргэдийн төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, сэргээх, хууль бус үйлдлийг үл хүлээн зөвшөөрөх, үл тэвчих ёс зүй, соёлыг нийгэмд бий болгох, төрийн байгууллагын хариуцлагатай байдал дээшлэхэд чухал ач холбогдол үзүүлэх ба авлига буурах, авлигатай тэмцэх төрийн бодлого чангарч, хууль бус хөрөнгө, орлогыг хураан авах, хохирол нөхөн төлүүлэх байдал сайжирч, шударга ёсны зарчим баталгаажна гэж үзэж байна.

Мөн төрийн албыг шударга, зөв, зүй зохистой, үр дүнтэй, ёс зүйтэй, хууль ёсны байлгахад үндэс суурь болох буюу хууль бус аргаар хөрөнгөждөг байдал арилахад томоохон эерэг нөлөө үзүүлэхээс гадна хууль бус хөрөнгийг хураан авч улсын орлого болгосноор төрөөс авч хэрэгжүүлж буй хөгжлийн болон нийгмийн хамгааллын арга хэмжээг санхүүжүүлэх боломж бүрдэнэ.

Авлигын эсрэг тус бодлогыг амжилттай хэрэгжүүлснээр олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх бөгөөд олон улсын холбогдох индекс, үзүүлэлт өсөхөд хувь нэмэр болох ба Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгасан “Авлигагүй төр болох” гол зорилтоо хангахад гол түлхэц болно.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ болон бусад хуультай уялдах нь, дагалдах хуулийн төслийн санал

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээнд нийцсэн байх бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хуульд нэмэлт оруулах тухай, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт

оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Прокурорын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон бусад шаардлагатай хуулийн төслийг боловсруулна.